



**ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 29

Бүрэнхайрхан

Хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.7, 20.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:


1.Сум орон нутгийн онцлогт тулгуурлан, иргэдийг байгалийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах, эрүүл аюулгүй, цэвэр орчинд ажиллаж амьдрах орчинг бүрдүүлэх зорилгоор “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, “Хог хаягдлын менежментийг сайжруулах” хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулж, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ



Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн
29 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



“ЖИМС ЖИМСГЭНЭ” хөтөлбөр

Нэг: Хөтөлбөрийн үндэслэл

Манай оронд зэрлэг болон таримал олон төрлийн жимс ургадаг бөгөөд иргэд амьдрал ахуйдаа тохируулан ашиглаж ирсэн түүхэн уламжлалтай. Жимс жимсгэний ургамал нь олон төрлийн амин дэмээр баялаг, будагч бодис элбэг учир хүнс, эмчилгээ, сувилгаанд өргөн хэрэглэгддэг төдийгүй ус чийг арвижуулах, хөрсийг элэгдлээс хамгаалах, цэцэг навч мөчир нь гоёл чимэглэлийн ач холбогдолтойгоос гадна төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоогоор насанд хүрсэн хүн жилд дунджаар 87,6 кг жимс жимсгэнэ хэрэглэх нь зохистой гэж үздэг. Манай сум жимс жимсгэний тариалалтаар сайн ч нэг хүн жилд дунджаар 4.2 кг хэрэглэж үлдсэн хувийг чанарын баталгаагүй импортын жимсээр хангагдаж байна.

Үүнийг дагаад хүний хоол хүнсний байгалийн цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүний нийлүүлэлт хумигдаж байна. Иймээс орон нутгийн онцлогт тулгуурлан олон арван жил эрхлэж ирсэн Булганчуудын нэрийн хуудас болсон байгалийн цэвэр бүтээгдэхүүн төрөл бүрийн жимсийг бүх нийтийн хүртээл болгох нь тулгамдсан асуудлын нэг болоод байна. Иймд Булганчуудыг витаминлаг эрүүл ахуйн шаардлага хангасан байгалийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах цаашлаад сумаас гадагш зах зээлд нийлүүлэх замаар иргэдийн амжиргааг дээшлүүлэх нэг гарц, боломж гэж үзэн Булган суманд жимсний аж ахуйг хөгжүүлэх түгээн дэлгэрүүлэх “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага үндэслэл урган гарч байна.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго

“Жимс жимсгэнэ” хөтөлбөрийг удирдлага болгон түүний хэрэгжилтийг эрчимжүүлж, жимс, жимсгэний тариалалт үйлдвэрлэлийг аж ахуйн болон өрхийн тариалангийн чиглэлээр өөрийн сумын онцлогт тохируулан хөгжүүлснээр жимсний талбайг нэмэгдүүлэх, цөлжилтөөс сэргийлэх, хөрс, байгаль хамгаалах, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангахад оршино.

Гурав: Хөтөлбөрийн зорилт

3.1. Жимсний аж ахуйг хөгжүүлэх нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлж, аж ахуй эрхлэгчдийг чадваржуулах, урамшуулан дэмжих боломжийг бүрдүүлэх,

3.2. Жимс тариалалт, үйлдвэрлэлийн талаар сургалт зохион байгуулах, Жимсчдийн холбоо нөхөрлөл байгуулах зэрэг үүсгэл санаачлагын байгууллагыг сум орон нутгийн зүгээс дэмжих, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, хүрээг өргөжүүлэх,

3.3. Жимсний аж ахуйг хөгжүүлж буй тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, иргэд олон нийтэд хүргэх, сурталчилах, мэдээлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх,

Дөрөв: Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Жимсний аж ахуйг хөгжүүлэх нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлж, аж ахуй эрхлэгчдийг чадваржуулах, урамшуулан дэмжих боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд

4.1.1. Сумын жимсчдийг нэгтгэсэн төрийн бус байгууллагатай болж үйл ажиллагааний уялдаа холбоог сайжруулах,

4.1.2. Хөтөлбөрийн хүрээнд өрх бүр жимсний аж ахуй эрхлэгч байх хөдөлгөөн өрнүүлэн дэмжих,

4.1.3. Аж ахуйн нэгж байгууллага бүр өөрийн онцлогт тулгуурлан жимсний талбай бий болгон үе шаттай нэмэгдүүлэх,

4.1.4. Аж ахуй эрхлэгчдийг шинээр болон давтан сургах, тэдэнд зориулсан сургалтуудыг холбогдох байгууллага, холбоодтой хамтран зохион байгуулах,

4.1.5. Аж ахуй эрхлэгч, аж ахуй эрхлэгчээсээ суралцах арга зүйг хэрэгжүүлэх,

4.1.6. Нийтийн эзэмшлийн талбай байгууламжуудыг жимсжүүлэх арга хэмжээг зохион байгуулах,

4.1.7. Тогтвортой, үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлж, багш, сургагч бэлтгэх,

4.1.8. Жимсний аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага, багш, сурагч нарыг урамшуулах,

4.2. Жимс тариалалт, үйлдвэрлэлийн талаар сургалт зохион байгуулах, Жимсчдийн холбоо нөхөрлөл байгуулах зэрэг үүсгэл санаачлагын байгууллагыг сум орон нутгийн зүгээс дэмжих, үзэсгэлэн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, хүрээг өргөжүүлэх зорилтын хүрээнд

4.2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөв, төсөл хөтөлбөрийн байгууллагын санхүүжилтээр шийдвэрлэх ажлыг зохион байгуулах,

4.2.2. Хүүхэд, залуучууд, өсвөрийн жимсчдийн дугуйлан хичээллүүлэх

4.2.3. Жимсний ач холбогдлыг сурталчилж, тэргүүний жимсчдийг алдаршуулах арга хэмжээг зохион байгуулах,

4.2.4. Сумын жимсчдийн тогтсон өдөртэй болж, уралдаан тэмцээн зохион байгуулж, хөхүүлэн дэмжих, Жимс, жимсгэний төрлөөр номинаци гаргаж шагнаж урамшуулах,

4.2.5. Жимсний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээ бий болгох үйл ажиллагааг сум орон нутгийн зүгээс дэмжиж, зохион байгуулах,

4.3. Жимсний аж ахуйг хөгжүүлж буй тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, иргэд олон нийтэд хүргэх, сурталчилах, мэдээлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд

4.3.1. Сум, орон нутаг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэд “Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хэрэгжилтийг мэдээллийн самбар, цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сум, аймаг, улсын хэмжээнд сурталчилах, мэдээлэх.

4.3.2. Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байгаа баг, байгууллага, иргэд, багш, сургагчдыг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулах,

4.3.3. Орон нутгаас төрөн гарсан сум, аймаг, улсын аварга, тэргүүний байгууллага, иргэдийг сурталчилах нэвтрүүлэг бэлтгэн нийтэд хүргэх,

Тав: Хөтөлбөр хэрэгжих хугацаа

Энэхүү хөтөлбөрийн 2017-2024 онд хэрэгжинэ.

Зургаа: Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөр нь улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөв, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хандив тусламж, иргэн, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.

Долоо: Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуур


д/д	Шалгуур үзүүлэлт	Гарааны түвшин \2016\	Хүрэх түвшин \2024\
1	Сум жимсчдийг нэгтгэсэн төрийн бус байгууллагатай болж үйл ажиллагааний уялдаа холбоог сайжруулах	Байхгүй	Төрийн бус байгууллагатай болсон байна.
2	Хөтөлбөрийн хүрээнд өрх бүр жимсний	Тогтмол биш	Тогтмолжсон

	аж ахуй эрхлэгч байх хөдөлгөөн өрнүүлэн дэмжих		байна.
3	Аж ахуйн нэгж байгууллага бүр өөрийн онцлогт тулгуурлан жимсний талбай бий болгон үе шаттай нэмэгдүүлэх	15 га	50 га
4	Аж ахуй эрхлэгчдийг шинээр болон давтан сургах, тэдэнд зориулсан сургалтуудыг холбогдох байгууллага, холбоодтой хамтран зохион байгуулах	Тогтмол биш	Тогтмолжсон байна.
5	Нийтийн эзэмшлийн талбай байгууламжуудыг жимсжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Байхгүй	5 га
6	Тогтвортой, үр бүтээлтэй ажиллах боломжийг бүрдүүлж, багш, сургагч бэлтгэх	Байхгүй	Агрономич, багштай болно.
7	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөв, төсөл хөтөлбөрийн байгууллагын санхүүжилтээр шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	СХСангаас 23,0 сая төгрөгөөр дэмжсэн	100,0 саяд хүрсэн байна.
8	Хүүхэд, залуучууд, өсвөрийн жимсчдийн дугуйлан хичээллүүлэх	Байхгүй	Тогтмолжсон байна.
9	Сумын жимсчдийн тогтсон өдөртэй болж, уралдаан тэмцээн зохион байгуулж, хөхүүлэн дэмжих. Жимс, жимсгэний төрлөөр номинаци гаргаж шагнаж урамшуулах	Байхгүй	Тогтмолжсон байна.
10	Жимсний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээ бий болгох үйл ажиллагааг сум орон нутгийн зүгээс дэмжиж, зохион байгуулах	Байхгүй	Барлуулалтын сүлжээ бий болсон байна.
11	Сум, орон нутаг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэд "Жимс жимсгэнэ" хөтөлбөрийн хэрэгжилтийг мэдээллийн самбар, цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр	Тогтмол биш	Сурталчилгаа, мэдээллийн ажил тогтмолжсон

	сум, аймаг, улсын хэмжээнд сурталчилах, мэдээлэх		байна.
12	Орон нутгаас төрөн гарсан сум, аймаг, улсын аварга, тэргүүний байгууллага, иргэдийг сурталчилах нэвтрүүлэг бэлтгэн нийтэд хүргэх	Тогтмол биш	Жил бүр 1-ээс доошгүй нэвтрүүлэг хийнэ.
13	Жил бүр 50-иас доошгүй өрхөд 5-аас доошгүй модын гурвалсан гэрээ байгуулан үнэгүй олгоно.	Байхгүй	250 өрхөд олгосон байна.

...оОо....

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн
29 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан ба хог хаягдлын менежментийг сайжруулж хог хаягдлыг бууруулах, хүн амын амьдрах тав тухтай эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр зорилтуудыг тодорхойлсон байдаг.

Хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилтийн нөлөөгөөр хог хаягдлын хэмжээ жил тутамд нэмэгдэхийн зэрэгцээ төрөл, бүтцийн хувьд ч өөрчлөгдөх болсон. Хог хаягдлын хэмжээ нэмэгдэж байгаагийн гол шалтгаан нь бараа, бүтээгдэхүүний хэрэглээ огцом өсч байгаатай холбоотой юм. Одоо сумын хэмжээнд 1 хог хаягдлын төвлөрсөн цэг ажиллаж, 25 га талбайг хамарч байна. Зөвхөн ердийн хог хаягдал төдийгүй үйлдвэрлэл, ахуйгаас гарах аюултай хог хаягдлын хэмжээ ч ихэсч, хур хуримтлал бий болсоор байна. Энэ талаар хийсэн тооллого судалгаа хог хаягдлын нэгдсэн бүртгэл, хяналтын ажил бараг бүхэлдээ орхигдсон байна.

Бодит байдал дээр хөдөө орон нутаг хогондоо дарагдсан байдал хэвээрээ, хог хаягдлын нэгдсэн менежментийн тогтолцоо төлөвшөөгүй, хатуу хог хаягдлыг ил задгай хамаагүй хаядаг, тогтмол хугацаанд татан зайлуулдаггүй, зөвхөн газарт дарж булах аргаар устгадаг, аюултай хог хаягдлыг устгах зориулалтын байгууламж байхгүйгээс ихээхэн хэмжээний хуримтлал үүссэн, хог хаягдлын цэгүүд эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгаа зэргээс хүрээлэн байгаа орчин бохирдож, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөөр байна.

Иймд ногоон хөгжлийн үзэл санааг дэлгэрүүлэн хог хаягдлын менежментийг шинэ шатанд гаргаж нөөц, түүхий эдийн хэмнэлттэй, үр ашигтай, хаягдал багатай цэвэр технологийг дэмжих замаар хог хаягдлын эх үүсвэр бууруулах, бохирдуулагч нь төлбөр төлөх, зарчимд тулгуурлан иргэдийн сэтгэлгээг өөрчилж, ухамсрыг дээшлүүлэх, хог хаягдлыг зайлуулах дэд бүтцийг бий болгох, чадавхийг бэхжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн

хариуцлагыг өндөржүүлж, бүх нийтийн оролцоотойгоор хамтдаа хог хаягдлыг бууруулж, цэвэр эрүүл орчинг бүрдүүлэх чиглэлээр зорилго, үйл ажиллагааг тодорхойлж нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

2.1. Нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээ, технологийг дэмжин хаягдлыг бууруулж, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хатуу хог хаягдлын зохистой менежментийг төлөвшүүлж, цэвэр эрүүл орчин бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг шийдвэрлэнэ:

2.2.1. хог хаягдлын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгож хэрэгжилтийг сайжруулах, хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх;

2.2.2. үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх замаар хог хаягдлыг бууруулах болон хаягдалгүй дэвшилтэт технологийг дэмжих, үйлдвэрлэлийн хог хаягдлын зохистой менежмент, хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

2.2.3. аюултай хог хаягдлын менежментийг сайжруулж байгаль орчинд хал багатайгаар зайлуулах чадавхийг бүрдүүлж, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлэх;

2.2.4. хүн амд ногоон хэрэглээний соёл, хог хаягдлыг ангилан ялгах, амьдрах орчны эрүүл ахуйн зөв дадлыг төлөвшүүлэх замаар амьдралын тав тухтай орчин бүрдүүлэх;

2.2.5. хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг бууруулах. Хогийн цэгийн цэгцэлж хаягжуулах.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглалтыг хөхүүлэн дэмжих;

3.1.2. хог хаягдлыг байгаль орчинд хал багатай арга технологиор зайлуулах;

3.1.3. хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, үйлдвэрлэл дээр нь бууруулах;

3.1.4. үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийг тухайн үүсгэгчээр нь хариуцуулах, бохирдуулагч нь төлбөр төлөх;

3.1.5. иргэд, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, түншлэлд тулгуурлах;

3.1.6. хог хаягдлын менежментийн тэргүүн туршлагыг өөрийн онцлогт тохируулан бүтээлчээр нэвтрүүлэх.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Хөтөлбөрийн 2.2.1-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоог бүрдүүлэх, үйлдвэрлэгч нь бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг эргүүлэн татаж ашиглах, хариуцлага хүлээлгэх, хог хаягдлыг бууруулах эдийн засгийн хөшүүрэг бий болгох;

4.1.2. хог хаягдлын тооллого явуулж, мэдээллийн сан бүрдүүлж хог хаягдлын хэмжээ, урсгалыг байнгын хяналттай болгох;

4.1.3. хог хаягдлын менежментийн тогтвортой санхүүжилтийн орчин, дэд бүтцийг бий болгох;

4.1.4. хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

4.1.5. хог хаягдлын менежментэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөнөөр ашиглаж, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх санал, санаачилгыг дэмжих.

4.2. Хөтөлбөрийн 2.2.2-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. үйлдвэрлэл эрхлэлтээс гарах хатуу хог хаягдлыг хянах, байгаль орчинд халгүй арга технологиор зайлуулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

4.2.2. нөөц, түүхий эдийн зарцуулалтыг багасгах, хэмнэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар хог хаягдлыг бууруулах, хаягдалгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих;

4.2.3. хог хаягдлыг бууруулах, менежментийг сайжруулах шийдлүүд, тэргүүн туршлагыг судалж, туршин нэвтрүүлэх;

4.2.4. хог хаягдал, хорт бодисын ялгарлаас үүдэлтэй орчны бохирдлыг хянах, хүрээлэн байгаа орчны чанарын бодит мэдээлээр хангагдах.

4.3. Хөтөлбөрийн 2.2.3-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.2. хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэл бүхий хог хаягдлыг халгүй аргаар зайлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор хог хаягдлыг дахин боловсруулах, устгал хийх үйл ажиллагааг дэмжих;

4.3.3. аюултай хог хаягдлыг устгах, түр хадгалах зориулалтын байр бий болгож, аюултай хог хаягдлын хяналтгүй тархалтыг хумих чадавхийг бүрдүүлэх;

4.3.4. аюултай хог хаягдлын талаарх хуулийн хэрэгжилтийг хангах, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах.

4.4. Хөтөлбөрийн 2.2.4-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, татан зайлуулахтай холбоотой заавар, аргачлал, стандартыг боловсруулж нэвтрүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах;

4.4.2. ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, зориулалтын уут сав хэрэглэх, хогийн цэгт хаях зэрэг дадал хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа өргөнөөр явуулах, иргэдийн санал, санаачилгыг дэмжих;

4.4.3. хог хаягдлыг бууруулах, амьдрах орчноо цэвэрлэж тохижуулах чиглэлээр нийтийг хамарсан компанит ажлуудыг зохион байгуулах;

4.4.4. сумын төвд эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн цэг байгуулах, өргөтгөх;

4.4.5. ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлын ангилал, дахин боловсруулалт, химийн бодисын зохистой хэрэглээ, хувь хүний нийгмийн хариуцлагын талаар олон нийтэд мэдлэг олгох.

4.5. Хөтөлбөрийн 2.2.5-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1. бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг үйлдвэрлэгч, борлуулагч эргүүлэн татаж ашиглах, дахин боловсруулах тогтолцоог нэвтрүүлэх;

4.5.2. хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих;

4.5.3. аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нийгмийн хариуцлагыг өндөржүүлж, худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчид хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бууруулах, олон дахин ашиглагдах бараа бүтээгдэхүүн нийлүүлэх:

Тав. Хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

Хог хаягдлыг бууруулах эрх зүй, зохион байгуулалтын орчныг боловсронгуй болгож, менежментийг сайжруулах, дэд бүтцийн болон санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, хог хаягдлыг бууруулах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн цогц бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Хог хаягдлаас үүдэлтэй орчны доройтлыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, ногоон хэрэглээний соёл, нийгмийн хариуцлагын ойлголтыг төлөвшүүлж, хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоо бий болж цэвэр эрүүл орчин бүрдэнэ.

Зургаа. Санхүүжилт

6.1. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 6.1.2. хог хаягдлын үйлчилгээний хураамж;
- 6.1.3. хандив, зээл, тусламж;
- 6.1.4. аж ахуйн нэгж, байгууллагаас гаргах хөрөнгө;
- 6.1.5. бусад эх үүсвэр.

Долоо. Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

7.1. Хөтөлбөр хэрэгжсэнээр хог хаягдлын зохистой менежментийн эхлэл тавигдаж, суманд эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагаа жигдэрч, нийт хог хаягдлын 10-аас доошгүй хувийг эргүүлэн ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дахин боловсруулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшиж, хог хаягдлын урсгалын статистик мэдээ, сан бүрдүүлэх, аюултай хог хаягдал хуримтлагдахаас сэргийлэх чадавх бүрдсэн байна.

...оОо...